



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 1619

Булган сум

Шагналын зардал шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Тэргүүний ажилтны тэмдэг болон аймгийн Засаг даргын жуух, баярын бичгийн хавтас, Тэргүүний үнэмлэх, хэвлэмэл хуудаснуудыг хэвлүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 19,650,000 (Арван есөн сая зургаан зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 05-ний өдрийн А/219 дугаар
захирамжийн хавсралт

Аймгийн Засаг даргын шагнал хэвлэлтийн зардал

Д/д	Шагналын нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	2	3	4	5
1	Жуух хавтас, дотор хэвлэл	500	15000	7.500.000
2	Баярын бичиг хавтас, дотор хэвлэл	500	10500	5.250.000
3	Аймгийн Тэргүүн хавтас, үнэмлэх	500	4000	2.000.000
4	Аймгийн Тэргүүний тэмдэг	350	14000	4.900.000
Дүн				19,650,000